

**“ХАРХОРИН” ХК-ИЙН 2026 ОНЫ 04-Р САРЫН 25-НЫ ӨДРИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04-р сарын 25 өдөр

Өвөрхангай аймаг, Хархорин сум

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 25-ны өдөр 14.00 цагаас Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байранд хурлын танхимд хуралдсан болно.

Тус хурлыг “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай 02/2026 дугаар тогтоолын дагуу зарлан хуралдуулсан болно.

Хурал болсон газар: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байр

Хурал болсон он, сар, өдөр, цаг: 2026 оны 04-р сарын 25-ны өдөр 14.00 цагаас

Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Пүрэвийн Учрал

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигч Сүрэнжавын Пүрэв (377,660 ш хувьцаатай), Долгорсүрэнгийн Дашмаа (100 ш хувьцаатай), Намхайн Рагчаа (100 ш хувьцаатай), Цэвээний Бүрэнжаргал (93 ш хувьцаатай), Лхамсүрэнгийн Энхтуяа (100 ш хувьцаатай), Чимэддоржийн Отгонсүрэн (93 ш хувьцаатай), Цэндсүрэнгийн Баасансүрэн (100 ш хувьцаатай) нар оролцсон болно. Хурал хуралдсан өдрийн байдлаар саналаа өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан өгсөн хувьцаа эзэмшигч бүртгэгдээгүй болно. Тус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрх бүхий хувьцааны нийт тоо 378,216 буюу 70.1% болсон.

Түүнчлэн тус хурал дээр компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд ТУЗ-ийн гишүүн П.Учрал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бөгөөд хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат, Тооллогын комиссын дарга М.Шавагцэрэн, Тооллогын комиссын гишүүн Ц.Болортуяа нар байлцсан. ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Амгалан, Б.Бүрэн нар зайнаас гар утсаараа холбогдож оролцсон болно.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Ганбат

Хурлын ирц: 70.1 хувь

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо болон хурлын ирцийн тухай:

Хурлын бүртгэх өдөр буюу 2026 оны 04-р сарын 06-ны өдрөөр тасалбар болгон “ҮЦТХТ” ХХК-с гаргуулсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаагаар “Хархорин” ХК-ийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий нийт 585 хувьцаа эзэмшигч, эдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшил, өмчлөлд нийт 539,515 ш саналын эрх бүхий хувьцаа байна гэж бүртгэгдсэн. Ийнхүү “Хархорин” ХК-ийн нийт 585 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлэхээс саналын эрх бүхий нийт 378,216 ш энгийн хувьцаа



эзэмшиж байгаа 7 хувьцаа эзэмшигч хуралд оролцож саналаа өгсөн. Хурлын ирц 70.1% болсон. Ирцийн тайлан дараах байдалтай байна:

д.д	Хуралд оролцсон, саналаа хэрхэн өгсөн	Хувьцаа эзэмшигчийн тоо	Хувьцааны тоо
1	Хуралд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцсон	7	378,216 (70.1%)
2	Хуралд биечлэн оролцоогүй, саналаа саналын хуудсаар ирүүлсэн	0	0 (0%)
	Нийт	7	378,216 (70.1%)

Компанийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцдог тул Хурал зохион байгуулах комиссын зүгээс тус хуралд биечлэн ирж оролцох боломжгүй байгаа хувьцаа эзэмшигчдийг саналаа өгөх боломжоор хангаж, хурлын зарыг СЗХ-ны холбогдох журмын дагуу явуулж, хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниудад хурлын холбогдох материалыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар нь pdf хэлбэрээр илгээсэн.

Тус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2026 оны 03-р сарын 16-ний өдрийн 02/2026 тоот тогтоолоор гаргасан. Хурлын мэдэгдлийг тогтоосон хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн. Мөн хурлын мэдэгдлийг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсан дээрх “Хархорин” ХК-ийн мэдээлэл хэсэгт байршуулсан.

Хурлыг зарлан хуралдуулах ажлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу явуулсан болно.

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтүүдийг хэлэлцэж батлах.
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Саналын хуудас хэрэглэсэн эсэх, саналын хуудасны загвар: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 16-ны өдрийн 02/2026 тоот тогтоолын хавсралтаар компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн ээлжит хуралд хэрэглэх саналын хуудасны загварыг баталж тус саналын хуудсаар санал хураалт явуулсан болно (Компанийн тухай хуулийн 71.1-ийн дагуу).

Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол:

Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.

Үүнд:

Асуудал 1: “Хархорин” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай.

1-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,216; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

1-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 2: “Хархорин” ХК-ийн 2025 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

2-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,216; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

2-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсэн болно.

Асуудал 3: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах тухай

3-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,216; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0. Хүчингүй саналын хуудас гараагүй болно.

3-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02-р сарын 13-ны өдрийн 01/2026 дугаар тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 144,146.8 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.

Асуудал 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Тухайн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Ганбат танилцуулсан болно: “Хархорин” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.23-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байдаг. Одоогийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдож байсан.

Иймд 04-р сарын 23-ны өдрөөр бүрэн эрх нь дуусгавар болсон. Иймд өнөөдрийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгох шаардлагатай. Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн зургаан гишүүн, хараат бус гурван гишүүнтэй байна. Энэ нь компанийн дүрмийн 7-р зүйлийн 7.22-т тусгагдсан. Ердийн гишүүнд Пүрэвийн Бишрэл, Пүрэвийн Учрал, Жаргалын Энхтөр, Ойдовсүрэнгийн Энхтөр, Пүрэвийн Халиун, Даваасүрэнгийн Ангар нарын нэрийг дэвшүүлж байгаа. Хараат бус гишүүдэд Сандагийн Амгалан, Баттулгын Бүрэн, Пүрэвсүхийн Нямдорж нарын нэрийг дэвшүүлж байгаа. Компани нь сүүлийн жилүүдэд үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй, санхүүгийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй байгааг хувьцаа эзэмшигчид ойлгож хүлээн авна уу. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 880 дугаар тогтоолоор батлагдсан Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмыг баримтлах болно. Энэ журмын дагуу саналаа хэрхэн өгөх талаар хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулъя. Санал хураалтын үед асууж лавлах зүйл байгаа бол тооллогын комиссын гишүүдээс асууж болно. (Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмыг уншиж танилцуулав)

Ийнхүү Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг санал хураах кумулятив аргаар хувьцаа эзэмшигчдээс санал хураасан.

4-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо СЗХ-ны 2020 оны 880 дугаар тогтоолоор батлагдсан Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмын дагуу тус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд өгсөн кумулятив саналыг тус тусад нь тоолсон. Нийт кумулятив саналын тоо 3,403,944, үүнээс ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа 6 нэр дэвшигчдэд нийт 2,269,296 кумулятив санал ирсэн. Нэр дэвшигч тус бүрд өгсөн саналыг тоолж үзэхэд нэр дэвшигч тус бүрд 378,216 санал ирсэн.

Хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа 3 нэр дэвшигчдэд нийт 1,134,648 кумулятив санал ирсэн. Эдгээрийг нэр дэвшигч тус бүрээр тоолж үзэхэд хараат бус гишүүнд нэр дэвшигч тус бүр 378,216 санал авсан байсан. Ийнхүү саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн кумулятив саналыг нийт 9 нэр дэвшигчдэд тэнцүү хуваарилж өгсөн байсан. Түдгэлзсэн санал гараагүй болно.

5-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол: Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн:

Нэг. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр Сандагийн Амгалан, Баттулгын Бүрэн, Пүрэвсүхийн Нямдорж нарыг томилов.

Хоёр. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Пүрэвийн Бишрэл, Пүрэвийн Учрал, Жаргалын Энхтөр, Ойдовсүрэнгийн Төмөрбаатар, Пүрэвийн Халиун, Даваасүрэнгийн Ангар нарыг томилов.

Бусад асуудал хэлэлцсэн эсэх: бусад асуудал хэлэлцээгүй болно.

Хурал өндөрлөсөн: 16.00 цагт хурал өндөрлөсөн болно

Хурлаар шийдвэрлэсэн нь:

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2026 оны 04-р сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрүүдийг гаргасан болно. Үүнд:

1. “Хархорин” нээлттэй хувьцаат компанийн 2025 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай гэж шийдвэрлэв.
2. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 144,146.8 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2025 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.
3. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр Сандагийн Амгалан, Баттулгын Бүрэн, Пүрэвсүхийн Нямдорж нарыг, “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Пүрэвийн Бишрэл, Пүрэвийн Учрал, Даваасүрэнгийн Ангар, Жаргалын Энхтөр, Ойдовсүрэнгийн Төмөрбаатар, Пүрэвийн Халиун нарыг тус тус томилох.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

Хурлын тэмдэглэл үйлдсэн

Б.Ганбат